



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/024/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням
Утас: 261663 Цахим хаяг: sambuunyam.ya@audit.mn
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхжин
Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Л.ГАНТӨМӨР ТАНАА

᠒᠐᠒5.04.᠒5 № 1592

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,307.6 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.3 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдад шинжлэх ухаан, технологийн

нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хариуцуулсантай холбоотойгоор сайдын багцад 1 Төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 Засгийн газрын тусгай сан, 13 Төсвийн шууд захирагч шилжин ирж мөн 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Үндэсний хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ыг байгуулж, нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн эрхийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тогтоосон. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Төрийн аудитын байгууллага “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас 95.4 хувиар үнэлж, Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гарган өгч, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,250,317,006.4	2,154,663,521.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	105,274,602.1	461,606,262.8
33	АВЛАГА	205,353.1	351,423,654.0
34	УРЬДЧИЛГАА	22,516.8	11,254,164.2
35	БАРАА МАТЕРИАЛ	595,586.8	5,886,609.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	44,978,178.5	1,540,340,627.1
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	1,325,758,767.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	44,978,178.5	214,581,860.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,295,295,184.9	3,695,004,148.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,606,091.0	1,895,816,139.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,606,091.0	168,797,979.8
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	107,972,671.9
41300	Өглөг	4,606,091.0	60,745,007.9
41400	Урьдчилж орсон орлого	-	80,300.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,727,018,159.9
42100	Урт хугацаат үнэт цаас	-	1,354,247,799.8
42200	Урт хугацаат зээл	-	372,770,360.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,290,689,094.0	1,799,188,009.2
51	Засгийн газрын хувь оролцоо	1,290,689,094.0	1,799,188,009.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,966,285.9	56,110,171.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	1,216,300,340.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,282,296,362.4	481,049,698.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,445.7	45,727,798.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,295,295,184.9	3,695,004,148.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	384,174,375.8	375,276,169.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,269,662.9	216,058,281.3
120	Нийтлэг татварын бус орлого	94,266,801.3	209,554,033.5
122	Тусламжийн орлого	2,861.6	6,504,247.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	289,904,712.9	159,217,888.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	53,881,488.2	332,272,397.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,881,488.2	332,272,397.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,063,430.9	196,933,534.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,800,810.6	68,270,657.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	541,954.0	8,289,457.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	249,426.6	2,385,068.1
2104	Хангамж, бараа материалын зардал	243,324.8	2,950,168.8
2105	Нормативт зардал	-	1,269,703.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,109.5	1,638,765.3
2107	Томилолт, зочны зардал	473,775.7	4,625,085.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,847,918.0	93,101,698.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,853,111.6	14,402,929.3

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

211	ХҮҮ	-	115,463,600.1
212	ТАТААС	-	238,442.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	818,057.4	19,636,820.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	330,292,887.6	43,003,772.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	74,422,298.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,787,607.4	133,049,968.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	319,505,280.2	(15,623,898.0)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	383,841,809.9	551,130,203.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,937,097.0	391,646,466.5
120	Нийтлэг татварын бус орлого	93,937,097.0	385,142,218.7
122	Тусламжийн орлого	-	6,504,247.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	289,904,712.9	159,483,736.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,173,060.1	414,146,329.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,173,060.1	414,146,329.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,347,738.1	222,476,927.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,805,884.5	65,392,360.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	589,119.4	8,168,049.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,756.5	2,184,833.1
2104	Хангамж, бараа материалын зардал	195,546.5	2,797,944.8
2105	Нормативт зардал	-	1,131,027.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	114,997.2	1,810,462.1
2107	Томилолт, зочны зардал	496,923.9	4,717,781.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,167,312.6	29,191,535.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	730,197.5	107,082,933.1
211	ХҮҮ	-	168,469,106.8
212	ТАТААС	-	239,997.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	825,322.0	22,960,297.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	367,668,749.8	136,983,874.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	275,594,549.9	102,310,457.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	275,594,549.9	102,310,457.7
2200	Дотоод эх үүсвэрээр	275,594,549.9	102,310,457.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(275,594,549.9)	(102,310,457.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	321,658,244.2
14	Бусад эх үүсвэр	-	952,639,967.6
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	630,981,723.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	92,074,199.9	356,331,660.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,200,402.2	105,274,602.1

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	105,274,602.1	461,606,262.8
----	---	---------------	---------------

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	971,690,888.8	-	971,690,888.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(507,075.0)	-	(507,075.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	971,183,813.8	-	971,183,813.8
9	Тайлант үеийн үр дүн	319,505,280.2	-	319,505,280.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,290,689,094.0	-	1,290,689,094.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	105,798,550.6	-	105,798,550.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,396,487,644.6	-	1,396,487,644.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(114,361.3)	-	(114,361.3)
17	Өмчид гарсан өөрчилөлт	430,134,626.4	-	430,134,626.4
19	Тайлант үеийн үр дүн	(27,319,900.5)	-	(27,319,900.5)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,799,188,009.2	-	1,799,188,009.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,147,521,600.00	144,131,296,653.50	39,016,224,946.50	78.7
УРСГАЛ ЗАРДАЛ	90,681,670,600.00	86,946,786,389.54	3,734,884,210.46	95.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,052,208,300.00	84,998,294,486.32	3,053,913,813.68	96.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,535,332,300.00	50,646,747,082.25	888,585,217.75	98.3
Үндсэн цалин	33,562,383,700.00	33,244,711,734.46	317,671,965.54	99.1
Нэмэгдэл	13,342,924,900.00	10,761,237,183.36	2,581,687,716.64	80.7
Унаа хоолны хөнгөлөлт	3,440,102,400.00	4,228,020,656.88	(787,918,256.88)	122.9
Урамшуулал	1,189,921,300.00	2,384,410,740.21	(1,194,489,440.21)	200.4
Гэрээт ажлын хөлс	-	28,366,767.34	(28,366,767.34)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,327,359,700.00	6,161,895,583.42	165,464,116.58	97.4
Тэтгэврийн даатгал	4,301,687,800.00	4,241,509,290.74	60,178,509.26	98.6
Тэтгэмжийн даатгал	511,238,800.00	504,890,271.75	6,348,528.25	98.8
ҮОМШӨ-ний даатгал	252,944,500.00	260,829,418.96	(7,884,918.96)	103.1
Ажилгүйдлийн даатгал	252,648,500.00	227,160,772.56	25,487,727.44	89.9
Эрүүл мэндийн даатгал	1,008,840,100.00	927,505,829.41	81,334,270.59	91.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,062,039,700.00	1,928,607,271.43	133,432,428.57	93.5
Гэрэл, цахилгаан	809,232,100.00	753,197,574.84	56,034,525.16	93.1
Түлш, халаалт	508,509,700.00	472,277,557.56	36,232,142.44	92.9
Цэвэр, бохир ус	217,273,700.00	176,107,339.03	41,166,360.97	81.1
Байрны түрээс	527,024,200.00	527,024,800.00	(600.00)	100.0
Хангамж, бараа материалын зардал	960,450,500.00	917,814,808.79	42,635,691.21	95.6

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бичиг хэрэг	159,269,000.00	150,570,464.97	8,698,535.03	94.5
Тээвэр, шатахуун	76,035,000.00	63,988,887.08	12,046,112.92	84.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,673,000.00	141,773,945.86	(5,100,945.86)	103.7
Ном, хэвлэл	338,833,100.00	323,763,985.00	15,069,115.00	95.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,837,500.00	15,566,020.00	4,271,480.00	78.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	229,802,900.00	222,151,505.88	7,651,394.12	96.7
Нормативт зардал	134,365,700.00	131,268,800.00	3,096,900.00	97.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	118,135,400.00	116,757,000.00	1,378,400.00	98.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,230,300.00	14,511,800.00	1,718,500.00	89.4
Эд хогшил, урсгал засварын зардал	4,779,202,100.00	4,720,921,160.05	58,280,939.95	98.8
Багаж, техник, хэрэгсэл	3,396,291,700.00	3,372,667,763.11	23,623,936.89	99.3
Тавилга	185,374,000.00	174,126,170.00	11,247,830.00	93.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	43,504,600.00	43,478,000.00	26,600.00	99.9
Урсгал засвар	1,154,031,800.00	1,130,649,226.94	23,382,573.06	98.0
Томилолт, зочны зардал	2,198,236,400.00	1,786,823,657.19	411,412,742.81	81.3
Гадаад албан томилолт	1,091,373,300.00	811,192,781.83	280,180,518.17	74.3
Дотоод албан томилолт	648,727,800.00	607,665,302.20	41,062,497.80	93.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	458,135,300.00	367,965,573.16	90,169,726.84	80.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,400,595,500.00	18,098,749,876.92	1,301,845,623.08	93.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,405,185,100.00	17,500,223,433.21	904,961,666.79	95.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	51,722,500.00	46,368,300.00	5,354,200.00	89.6
Даатгалын үйлчилгээ	13,176,200.00	11,316,270.00	1,859,930.00	85.9
Тээврийн хэрэгслийн татвар	3,614,200.00	2,858,081.00	756,119.00	79.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	345,800.00	242,200.00	103,600.00	70.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	871,835,000.00	510,320,448.71	361,514,551.29	58.5
Газрын төлбөр	30,965,300.00	24,481,144.00	6,484,156.00	79.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	424,300.00	-	424,300.00	0.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,327,100.00	2,940,000.00	20,387,100.00	12.6
Бараа үйлчилгээний бусад зардал	654,626,400.00	605,466,246.27	49,160,153.73	92.5
Бараа үйлчилгээний бусад зардал	258,523,700.00	236,306,160.00	22,217,540.00	91.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,102,700.00	369,160,086.27	26,942,613.73	93.2
ТАТААС	1,247,262,000.00	865,718,086.19	381,543,913.81	69.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,247,262,000.00	865,718,086.19	381,543,913.81	69.4

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,247,262,000.00	865,718,086.19	381,543,913.81	69.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,382,200,300.00	1,082,773,817.03	299,426,482.97	78.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	284,299,300.00	185,591,161.17	98,708,138.83	65.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	284,299,300.00	185,591,161.17	98,708,138.83	65.3
Бусад урсгал шилжүүлэг	1,097,901,000.00	897,182,655.86	200,718,344.14	81.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	134,931,900.00	130,359,400.00	4,572,500.00	96.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	889,883,500.00	695,495,221.86	194,388,278.14	78.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	73,085,600.00	71,328,034.00	1,757,566.00	97.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,465,851,000.00	57,184,510,263.96	35,281,340,736.04	61.8
Барилга байгууламж	91,682,851,000.00	56,538,184,163.96	35,144,666,836.04	61.7
Тоног төхөөрөмж	783,000,000.00	646,326,100.00	136,673,900.00	82.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	183,147,521,600.00	144,131,324,253.50	39,016,197,346.50	78.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	180,674,630,200.00	141,846,021,301.56	38,828,608,898.44	78.5
Улсын төсвөөс санхүүжих	180,674,630,200.00	141,846,021,301.56	38,828,608,898.44	78.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,472,891,400.00	2,285,302,951.94	187,588,448.06	92.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,472,891,400.00	2,212,542,572.94	260,348,827.06	89.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	72,760,379.00	(72,760,379.00)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,043	3,919	124	96.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	31	31	-	100.0
Төсвийн байгууллага	31	31	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	2,006	1,944	62	96.9
Удирдах ажилтан	63	70	(7)	111.1
Гүйцэтгэх ажилтан	1,700	1,634	66	96.1
Үйлчлэх ажилтан	243	240	3	98.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	20,824,605,990.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	20,824,605,990.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17,248,109,412.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,889,627,349.90
210101	Үндсэн цалин	-	1,636,855,071.95
210102	Нэмэгдэл	-	78,867,482.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,191,000.00
210104	Урамшуулал	-	5,911,110.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,152,802,685.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	336,540,319.72
210201	Тэтгэврийн даатгал	-	306,246,508.85
210202	Тэтгэмжийн даатгал	-	7,966,026.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,985,013.29
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,661,728.43
210205	Эрүүл мэндийн даатгал	-	13,681,042.64

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	59,258,334.91
210301	Гэрэл, цахилгаан	-	51,313,697.20
210302	Түлш, халаалт	-	3,836,437.71
210303	Цэвэр, бохир ус	-	4,108,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,526,062,620.41
210401	Бичиг хэрэг	-	229,617,455.76
210402	Тээвэр, шатахуун	-	433,176,415.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	36,774,682.27
210404	Ном, хэвлэл	-	477,161,653.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	7,421,563.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	341,910,850.87
2105	Нормативт зардал	-	1,002,882,965.84
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	899,664,216.34
210502	Хоол, хүнс	-	89,868,179.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	13,350,570.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,003,522,442.56
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,618,019,400.56
210602	Тавилга	-	27,710,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	98,127,659.00
210604	Урсгал засвар	-	259,665,383.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,415,985,738.50
210701	Гадаад албан томилолт	-	384,264,010.35
210702	Дотоод албан томилолт	-	2,001,338,622.15
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	30,383,106.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,128,772,332.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,093,233,805.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	6,772,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	22,522,000.00
210807	Газрын төлбөр	-	2,244,527.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,885,457,308.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,505,071,517.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	380,385,790.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,576,496,578.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	56,380,283.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	56,380,283.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,520,116,295.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,520,116,295.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	20,824,605,990.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	20,824,605,990.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,559,812,874.90
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,002,307,903.62
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,475,820,297.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,786,664,915.16

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,749.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,739.5 сая төгрөгийн алдааг залруулж, 9.6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн залруулаагүй алдаа:

- Ажилтанд олгох 2023 оны урамшууллын мөнгийг тайлант онд бодож олгон, зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;
- Дансны ангилал зөрүүлэн эм боох материалыг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэн байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 байгууллагын тайлан нэгтгэснээс “Өөрчлөлтгүй” 13, “Хязгаарлалттай” 3 санал дүгнэлт өгч, 19 байгууллага түүвэрт хамрагдсан байна. “Монгол Улсын Хөгжлийн банк ХХК”-нд төрийн аудит дүгнэлт гаргаагүй болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 6,634.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил² нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,307.6 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.

3.1.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын техник хяналтын зардлыг концесс эзэмшигч эрх бүхий байгууллагын дансанд шилжүүлж, хатуу хучилттай авто замын барилгын ажилд байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 онд нийт 2,868.1 сая төгрөгөөр байгуулсан байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрийг 2015 оноос хойш тухай бүр эрх бүхий байгууллагаас хяналт гүйцэтгэх аж ахуйн нэгжид шилжүүлж ирсэн бөгөөд 2024 онд Эдийн засаг, хөгжлийн яам гэрээний үлдэгдэл төлбөр болох 1,095.6 сая төгрөг шилжүүлж, гэрээний үнийн дүнгийн 10 хувь болох 286.8 сая төгрөгийг холбогдох баримт бичгийг хүлээлцсэний дараа шилжүүлснээр хяналт гүйцэтгэх аж ахуйн нэгжид төлөх техник хяналтын зардлын төлбөр бүрэн барагдахаар байна. Концесс эзэмшигчээс шилжүүлсэн техник хяналтын зардал болон хатуу хучилттай авто замын барилгын ажилд байнгын хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээний үнийн дүнгийн зөрүү 2,443.8 сая төгрөгийг Эдийн засаг, хөгжлийн яамны захиалагчийн хяналтын зардал болон барьцаа дансанд байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", 45.2.3-т "хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалагчийн хяналтын зардал болон барьцаа дансанд байршиж буй 2,443.8 сая төгрөгийг зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Харьяа байгууллагуудын зөрчилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: МУТШСБЭЗХС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,191.1 сая төгрөгийн 112 зөрчил илэрснээс 219.1 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 786.9 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага хүргүүлж, 3,185.1 сая төгрөгийн зөрчилд 70 зөрчилд зөвлөмж өгч, 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.
- Нийт залруулагдаагүй 6,634.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,307.6 сая төгрөгөөр давсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн нийт зөрчлийн дүнг 20 хувиар бууруулж ажиллах.

2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 7-р сарын 10-ны өдрийн хуулиар Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шинжлэх ухааны байгууллагууд шилжин ирсэнтэй холбоотойгоор шинжлэх ухааны судалгааны, спорт танхимын барилга болон шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилга байгууламжийн 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт МУТШСБЭЗХС-ын 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдаж санхүүжилтийг олгосон байна. Гэвч, тус барилга байгууламжийн эхний үлдэгдэл буюу өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, данс бүртгэлд бүртгэсэн хөрөнгө МУТШСБЭЗХС-ын санхүүгийн тайланд шилжиж ирээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шинжлэх ухааны судалгааны, спорт танхимын барилга болон шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилга байгууламжийн эхний үлдэгдэл буюу өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, данс бүртгэлд тусгасан хөрөнгийг санхүүгийн тайланд шилжүүлэн авах.

3. Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, 2023 онд бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн 20,427.4 сая төгрөгийн 47 барилга, байгууламж, автозам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл байна. ТЭЗҮ-ийг ашиглагч байгууллагад шилжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулаагүйгээс ТЭЗҮ-ийн магадлалын дүгнэлтийн хугацаа хүчингүй болох, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 29¹ дүгээр зүйлийн 29¹.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх", 29¹.2.2-т "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх", 29¹.2.3-т "техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй ТЭЗҮ-ийг ашиглагч байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Уул уурхайн хүрээлэн, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Цөмийн физикийн судалгааны төв, Ой модны сургалт, судалгааны хүрээлэн, Дулааны, техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгүүд Засгийн газрын тогтоолгүй шилжиж ирсэн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Эрдэм шинжилгээний зарим байгууллагын харьяалал өөрчлөх тухай" 154 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 328 дугаар тогтоолын хавсралтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэргүй шилжин ирсэн байгууллагуудыг шилжүүлэн авах талаар тогтоол, шийдвэр гаргуулах.

3.2 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 1,749.1 сая төгрөгийн 38 алдаа илэрснээс аудитын явцад 1,739.5 сая төгрөгийн алдааг залруулж, 9.6 сая төгрөгийн 2 алдааг дахин

давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 219.1 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 786.9 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага, хариуцлага тооцуулах 3 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 3,185.1 сая төгрөгийн зөрчилд 70 зөвлөмж өссөн.

3.2.1 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Шинжлэх ухааны паркийн захиргаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, дараа онд буюу он дамнан хэрэгжих 14.4 сая төгрөгийн ажил, үйлчилгээний гэрээг тайлант оны эцэст байгуулан санхүүжилтийг олгож, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа онд хэрэгжүүлэх ажил үйлчилгээний гэрээний төлбөрийг тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2.Илрүүлэлт: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь Төрийн аудитын байгууллагаас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 20.0 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, биелэлтийг ирүүлээгүй зөрчилд тус хүрээлэнгийн захиралд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлээ.

3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Анагаах ухааны хүрээлэнгийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 424.1 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар

зүйлд “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

2.Илрүүлэлт: Уул уурхайн хүрээлэнгийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 280.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 7 дугаар зүйлд “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

3.Илрүүлэлт: Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 109.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 7 дугаар зүйлд “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

4.Илрүүлэлт: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 837.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 7 дугаар зүйлд “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

2. Гадаад томилолтой холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Шинжлэх ухааны паркийн захиргаа нь бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 1.6 сая төгрөгийн гадаад томилолтын зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т заасан Бараа үйлчилгээний бусад зардал “Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа, үйлчилгээнд төлөх зардал буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль, тогтоомж, эрх зүйн бусад

шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил, үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд энд хамаарна." гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу зарцуулж байх.

2.Илрүүлэлт: Шинжлэх ухааны паркийн захиргаа нь "Шинжлэх ухааны паркийн захиргаа"-ны захирлын 2024 оны А/17 дугаар тушаалаар гадаад албан томилолтын зардлыг батлахдаа Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй 1.4 сая төгрөгийн орчуулагчийн зардлыг төсөвлөж, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" журамд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадаад албан томилолтын батлагдсан нормативаас илүү зардал төсөвлөн, санхүүжилт олгохгүй байх.

3. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Уул уурхайн хүрээлэн нь аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй зураг төсөл боловсруулах гэрээт ажил гүйцэтгүүлж 19.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй ажил үйлчилгээнд санхүүжилт олгохгүй байх.

4. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн нь батлагдсан төсвийг зохистой удирдаагүй, тайлант онд ажилчидтай холбоотой нийт 5.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх.

5. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндэсний хөгжлийн хүрээлэн нь төсвийг үр ашиггүй зарцуулж, 0.6 сая төгрөгөөр шатар хүлэгт тоглоом, 0.6 сая төгрөгөөр ажилчдын хэрэгцээнд сандлын зөөлөвч тус тус худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.

6. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд 3-аас дээш жилийн насжилттай 11.6 сая төгрөгийн авлага, 157.4 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Удаан жилийн насжилттай авлага, өглөгийн эзэн холбогдогчийг нь тодорхойлох арга хэмжээ зохион байгуулж, нийт авлага, өглөгийг 20.0 хувиар бууруулж ажиллах.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

Түүврийн байгууллагууд

Илрүүлэлт 1: Үндэсний хөгжлийн хүрээлэн нь тайлант оны эцэст 0.9 сая төгрөгийн ус, ундаа худалдан авч, шаардлагагүйгээр их хэмжээний бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хэрэгцээ шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 2: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь тайлант оны эцэст 2.5 сая төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч, шаардлагагүйгээр их хэмжээний бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хэрэгцээ шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх зөвлөмж өглөө.

3.4 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн нийцлийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 албан шаардлага хүргүүлж, 11 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн аудитын асуудлын талаарх дараах зөрчил илэрлээ.

Түүврийн байгууллагууд

Албан шаардлага:

1. Илрүүлэлт: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн орон тооны дээд хязгаарыг 105 байхаар баталсан байна. Тус хүрээлэн нь орон тоо, албан тушаалын жагсаалтад батлагдаагүй 4 албан тушаалын чиг үүргийг нэр бүхий албан хаагчдаар хавсран гүйцэтгүүлж, цалин олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Эрдэм шинжилгээний байгууллага, төвийн орон тооны дээд хязгаар, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тоо, албан тушаалын жагсаалтад батлагдаагүй албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Илрүүлэлт: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Анагаах ухааны хүрээлэнгийн орон тооны дээд хязгаарыг 46 байхаар баталсан байна. Тус хүрээлэн нь, орон тоо, албан тушаалын жагсаалтад батлагдаагүй 4 албан тушаалын чиг үүргийг нэр бүхий албан хаагчдаар хавсран гүйцэтгүүлж, цалин олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Эрдэм шинжилгээний байгууллага, төвийн орон тооны дээд хязгаар, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тоо, албан тушаалын жагсаалтад батлагдаагүй албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж:

1. Илрүүлэлт: Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/01 тоот тушаалаар Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын албан хаагчдын цалингийн хэмжээг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримтлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-д "Захирал дараах эрх, үүрэгтэй", 1.4/-д "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д "Төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ,

сүлжээг энэ хуулийн 9.2-т нийцүүлэн энэ хуульд заасан журмаар тогтооно", 57 дугаар зүйлийн 57.5-д "Доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно", 57.5.3-т "шүүхийн захиргааны байгууллага, Шүүхийн сахилгын хорооны албан хаагчаас бусад захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын цалингийн хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримталж тогтоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засгийн газрын тусгай сан													
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	1	17.5			1	17.5	1	17.5				
	Дүн	1	17.5	-	-	1	17.5	1	17.5	-	-	-	-
Төсвийн шууд захирагч													
1	Эдийн засаг, хөгжлийн яам	2	204.0			2	204.0	2	204.0				
2	Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	9	277.7	3	9.1	6	268.6	9	277.7				
3	Оюуны өмчийн газрын	2	61.7			2	61.7	2	61.7				
4	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2	7.0	1	2.6	1	4.4	2	7.0				
5	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	2	9.6			2	9.6		-	2	9.6	2	9.6
6	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	1	354.9			1	354.9	1	354.9				
7	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	2	23.6			2	23.6	2	23.6				
8	Академи-Биологийн хүрээлэн	4	200.5			4	200.5	4	200.5				
9	Академи-Одон орон, геофизикийн хүрээлэн	2	339.2			2	339.2	2	339.2				
10	Академи-Палеонтологийн хүрээлэн	5	143.0			5	143.0	5	143.0				
11	Академи-Физик технологийн хүрээлэн	2	105.4			2	105.4	2	105.4				
12	Академи-Хими, химийн технологийн хүрээлэн	4	5.1	1	5.1	3	-	4	5.1				
	Дүн	37	1,731.7	5	16.8	32	1,714.9	35	1,722.1	2	9.6	2	9.6
	Нийт дүн	38	1,749.2	5	16.8	33	1,732.4	36	1,739.6	2	9.6	2	9.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч													
1	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	4	2,443.8	1	2,443.8			3	-				
	Дүн	4.	2,443.8	1.0	2,443.8	-	-	3.0	-	-	-	-	-
Төвлөрүүлэн захирагч													
1	Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	5	18.2			3	14.5	2	3.7				
	Дүн	5	18.2	-	-	3	14.5	2	3.7	-	-	-	-
Засгийн газрын тусгай сан													
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	11	589.2	2	25.0	7	546.3	2	17.9				
	Дүн	11	589.2	2	25.0	7	546.3	2	17.9	-	-	-	-
Төсвийн шууд захирагч													
1	Эдийн засаг, хөгжлийн яам	14	1,172.4	1	171.0	1	56.3	12	945.1				
2	Академи-Философийн хүрээлэн	2	69.2		-	1	8.6	1	60.6				
3	Академи-Газарзүй, гео-экологийн хүрээлэн	2	113.7		-		-	2	113.7				
4	Академи-Археологийн хүрээлэн	1	22.9		-		-	1	22.9				
5	Академи-Биологийн хүрээлэн	4	22.6		-	1	18.6	3	4.0				
6	Академи-Технологи инкубатор	3	33.4	1	0.3	2	33.1		-				
7	Академи-Одон орон, геофизикийн хүрээлэн	4	50.9	1	4.1		-	3	46.8				
8	Академи-Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	5	17.6	2	4.5	1	-	2	13.1				
9	Академи-Хими, химийн технологийн хүрээлэн	4	12.2		-	1	-	3	12.2				
10	Академи-Физик, технологийн хүрээлэн	4	2.7	1	0.3		-	2	2.4	1	1		
11	Академи-Палеонтологийн хүрээлэн	4	38.5	1	1.9	2	36.6	1	-				

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

12	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	8	73.8	1	2.0	2	20.7	5	51.1				
13	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	5	11.1	1	9.0	1	2.1	3	-				
14	Монгол Улсын Их сургуулийн харьяа Цөмийн физик судалгааны төв	4	1.9		-	1	-	3	1.9				
15	Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	5	10.5	1	0.7		-	3	9.8	1	1		
16	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	8	23.8	1	0.3	2	5.2	5	18.3				
17	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	3	0.2		-		-	3	0.2				
18	Оюуны өмчийн газар	2	30.5		-	2	30.5		-				
19	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	4	1,008.6		-		-	3	1,008.6	1	1		
20	Анагаах ухааны хүрээлэн	1	424.0		-		-	1	424.0				
21	Шинжлэх ухааны паркийн захиргаа	3	17.4		-	1	14.4	2	3.0				
22	Уул уурхайн хүрээлэн	2	299.2		-		-	2	299.2				
23	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	2	114.9		-		-	2	114.9				
24	Үндэсний хөгжлийн хүрээлэн	2	2.1		-		-	2	2.1				
Дүн		96	3,574.1	11	194.1	18	226.1	64	3,153.9	3	3	-	-
Нийт дүн		116	6,625.3	14	2,662.9	28	786.9	71	3,175.5	3	3	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Засгийн газрын тусгай сан											
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	1	-					1	-		
Дүн		1	-	-	-	-	-	1	-		
Төсвийн шууд захирагч											
1	Эдийн засаг, хөгжлийн яам	1	-					1	-		
2	Академи-Физик технологийн хүрээлэн	1	7.8			1	7.8				
3	Академи-Палеонтологийн хүрээлэн	1	-					1	-		
4	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	1	33.3			1	33.3				
5	Анагаах ухааны хүрээлэн	1	-					1	-		
6	Оюуны өмчийн газар	1	-							1	1
Дүн		6	41.1	-	-	2	41.1	3	-	1	1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	1	-					1	-		
Дүн		1	-	-	-	-	-	1	-	-	-
Төвлөрүүлэн захирагч											
1	Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	3	-			1	-	2	-		
Дүн		3	-	-	-	1	-	2	-		
Засгийн газрын тусгай сан											
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	1	-			1	-				
Дүн		1	-	-	-	1	-	-	-		
Төсвийн шууд захирагч											
1	Эдийн засаг, хөгжлийн яам	2	-					2	-		
2	Академи-Палеонтологийн хүрээлэн	2	-					2	-		
3	Академи-Хими химийн технологийн хүрээлэн	1	-			1	-				
4	Академи-Олон улс судлалын хүрээлэн	1	-					1	-		
5	Академи-Түүх, угсаатны зүйн хүрээлэн	2	-					2	-		

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

6	Дулааны техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	1	15.0			1	15.0				
7	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн	1	-			1	-				
8	Анагаах ухааны хүрээлэн	1	-			1	-				
9	Оюуны өмчийн газар	2	165.4			2	165.4				
10	Үндэсний хөгжлийн хүрээлэн	1	-					1	-		
Дүн		14	180.4	-	-	6	180.4	8	-	-	-
Нийт дүн		26	221.5	-	-	10	221.5	15	-	1	1